

2024 оны 03 сарын 07-ны өдөр

Дугаар 2024/08

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах өдрийг
өөрчлөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 2024 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн 2024/4 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 07-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит бус хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдан зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 2024/04 тоот тогтоолын 3 дугаар заалтад заасан “ногдол ашиг тараах хугацаа 2024 оны 7 дугаар сарын 04-ний өдөр” гэснийг “ногдол ашиг тараах хугацаа 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр” гэж өөрчилсүгэй.
2. Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилж, холбогдох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуй нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, хуваарилахтай холбоотой төлбөр тооцоог “Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК-иар зуучлуулан гүйцэтгүүлж, ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр тараасугай.
3. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
4. Шийдвэртэй холбоотой мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох байгууллага болон нийтэд мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад даалгасугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, холбогдох гэрээ хэлцэл байгуулж, төлбөр тооцоог хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Г.Тэлмэн)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын хороонд үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

